

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 09 дүгээр 29-ний өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн үзлэг хүлээгдэл багатай байна. Эмнэлгийн хэмжээнд 6 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна.

Оношилгооны чиглэлээр MRI, КТГ маш их хүлээгдэлтэй, нийт 826 үйлчлүүлэгч 2-с дээш хоног багажийн шинжилгээ хийлгэхээр хүлээж байнгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна./ Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлэгт оношилгоо хийлгэхээр хүлээж
буй үйлчлүүлэгчдийн тоо**

№	Оношилгоо	Хүлээгдэл			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	MRI	30	50	530	610
2	КТГ	72	144	-	216
	БҮГД	102	194	530	826

Тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааралтайгаар тус эмнэлэгт MRI хийлгэхээр 610 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 87% нь 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. КТГ хийлгэхээр 216 үйлчлүүлэгч хүлээж байна. MRI шинжилгээ хийлгэх шаардлагатай эмчлүүлэгчийн тоо их байгаа тул 2023 оны цаг тараагдаж дууссан байна.

Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Ор хүлээж байгаа нийт 832 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 2/.

**Хүснэгт 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл.**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Чих, хамар, хоолой судлал	23	44	86	165	318
2	Нүд судлал	22	30	50	200	302
3	Урологи	20	30	50	10	110
4	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	6	13	22	-	41
5	Хоол боловсруулах эрхтэн судлал	9	8	-	-	17
6	Зүрх судасны эмгэг судлал	1	3	5	7	16
7	Дотоод шүүрэл судлал	2	8	2	-	12
8	Цусны эмгэг судлал	1	5	2	-	8

9	Мэдрэл судлал	-	2	1	-	3
10	Уушиг судлал	1	-	1	-	2
11	Хэрх үе судлал	2	-	-	-	2
12	Бөөрний эмгэг судлал	-	-	1	-	1
	НИЙТ	87	143	220	382	832

Чих, хамар, хоолой судлал, Нүд судлал, Урологийн тасагт хэвтэхээр хамгийн их буюу нийт 730 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь нийт орны хүлээгдлийн дийлэнх буюу 88%-ийг эзэлж байлаа. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн ихэнх буюу 90% нь 7-с дээш хоног хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ өмнөх саруудтай ижил хэмжээнд байна. Нийт 128 үйлчлүүлэгч амбулаторийн 8 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Мэдрэл судлал, Хоол боловсруулах эрхтэн судлал, Зүрхний эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Мэдрэл судлал	1	1	24	26
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	4	18	24
3	Зүрхний эмгэг судлал	21	1	1	23
4	Мэс засал судлал	3	-	18	21
5	Бөөр судлал	3	1	10	14
6	Нүд судлал	1	-	7	8
7	Чих хамар хоолой судлал	1	2	4	7
8	Эмэгтэйчүүд судлал	3	-	2	5
	НИЙТ	35	9	84	128

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр 128 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаагийн талаас илүү буюу 65% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 57 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. Хэвлийн эхо-д харуулахаар 23, Рентген оношилгоо хийлгэхээр 23, MRI оношилгоо хийлгэхээр 11 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна. Шинжилгээ өгөхөөр нийт 26 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 17 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл маш ихтэй байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 392 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 148 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	12	37	59	40	148
2	Чих, хамар, хоолой судлал	-	25	35	30	100
3	Уламжлалт эмчилгээний тасаг	18	23	15	21	77
4	Зүрх судасны эмгэг судлал	12	10	15	-	37
5	Мэс засал судлал	3	7	9	-	19
6	Урологи	3	4	-	-	7
7	Мэдрэл судлал	2	2	-	-	4
	НИЙТ	50 12.7%	108 27.5%	133 34%	91 25.8%	392 100%

Мөн Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 100 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Хэвтүүлэн эмчлүүлэхээр хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн хамгийн их буюу 34% /133/ нь 15-30 хоног хүртэл хугацаагаар ор хүлээж байна.

3. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 125 үйлчлүүлэгч 3-6 хоног, 93 үйлчлүүлэгч 7-14 хоног, нийт 218 хүн хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь тус эмнэлгийн хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна.

4. Геронтологийн үндэсний төв

Тус төвд дүрс оношилгоо хийлгэхээр 8 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж байгаа ба бусад тусламж үйлчилгээнд хүлээгдэлгүй байна.

5. Хүрээ амаржих газар ТМЭ хүлээгдэлгүй ажиллаж байна.
6. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.